# Техникийн тодорхойлолт

Нийлүүлэх бараа нь доор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна.

**Барааны нэр:** Нийгмийн даатгалын нэгдсэн мэдээллийн системд нэмэлт өөрчлөлтийг хийх программ хангамжийн хөгжүүлэлт

1. 2023 оны 07 дугаар сарын 07-ний өдрийн УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар нийгмийн даатгалын багц хуулийг шинэчлэн батлагдсантай холбогдуулан нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн системд хуулийн өөрчлөлтийн дагуу дараах нэмэлт хөгжүүлэлт хийх:

| *№* | *Захиалагчийн техникийн тодорхойлолт (Хийгдэх өөрчлөлтийн агуулга)* | | *Санал болгож буй техникийн тодорхойлолт (захиалагчийн техникийн тодорхойлолтыг хуулахгүй байхыг анхаарна уу. Зөвхөн санал болгож буй барааны техникийн тодорхойлолтыг бичнэ үү.)* | *Тайлбар (дээрх үзүүлэлтийг нотлох баримт бичиг болон танилцуулгыг хавсаргана)* |
|---|---|---|---|---|
| | **Хуулийн заалт** | **Нийгмийн даатгалын ерөнхий хууль** | | |
| | | Албан журмын даатгуулагчийн төрлийн код, шимтгэлийн хувь хэмжээ өөрчлөгдсөнийг системд тохируулах /ХНХСайд, Сангийн сайдын 2024.03.06-ны өдрийн №А/44, А/40 тоот тушаалаар баталсан хавсралтын дагуу/ | | |
| | | Тэтгэвэр авагч ажилтан нь тэтгэврийн даатгалын санд сонголтоор төлөх өөрчлөлт оруулах. Кодыг зөв тохируулах, жил жилд харгалзах насны шалгуурыг зөв шалгах; | | |
| | | Үндсэн болон зэрэгцсэн ажлын байрыг ялгах код тохируулах; | | |
| | | Монгол Улсаас хилийн чанадад ажиллаж байгаа Дипломат төлөөлөгчийн газрын ажилтны ажил хөдөлмөр эрхлээгүй нөхөр, эхнэрийг шимтгэлийн тайланд тусгахад өндөр насны тэтгэвэр тогтоолгоогүйг шалгах шалгуур нэмэх; | | |
| | | Иргэний гэрээгээр ажиллаж албан журмаар шимтгэл төлж буй даатгуулагчийг код /02001/-оор ялгаж, эдгээр даатгуулагч СДД давхардуулан төлж болохоор өөрчлөлт оруулах; | | |
| | | Дээрх тохиолдолд тэтгэвэр тэтгэмж тооцохдоо албан журмын болон СДД-ын цалингийн нийлбэрээс тооцох өөрчлөлтийг оруулах; | | |
| | | Дээрх тохиолдолд тэтгэвэр, тэтгэмж тооцох ЦХТАО-ын дээд хэмжээг албан журмын даатгуулагчид баримталж буй ЦХТАО-ын дээд хэмжээгээр тооцох; | | |
| | | Тэтгэврийн шинэ тогтоолт хийхэд ЦАХ-ны болон энгийн өндөр насны тэтгэврийг давхардуулан тогтоох нөхцлийг хааж, аль нэг тэтгэвэр рүү нь нэгтгэн тогтоох өөрчлөлтийг оруулах; | | |
| 9 | | Албан журмын даатгуулагчийн ҮОМШӨ-ий даатгалын санд төлөх хувь хэмжээг 0.5% болгон бууруулах өөрчлөлт оруулах; | | |
| | | Албан журмын даатгуулагчийн ажилгүйдлийн даатгалын санд ажил олгогчоос төлөх хувь хэмжээг 0.5 болгон өсгөх өөрчлөлт оруулах; | | |
| | | ҮОМШӨ-ний даатгалын санд төлөх шимтгэлийн хувь хэмжээг даатгуулагчийн ажлын байрны нөхцлөөс хамааруулан ялгаатай тооцох өөрчлөлтийг оруулах;<br>/Монгол Улсын Засгийн газрын “Жагсаалт журам батлах тухай” 2023.12.27-ны өдрийн №471 тоот тогтоолын дагуу үндэсний ажил мэргэжлийн ангилалд харгалзуулан баталсан хувь хэмжээгээр ажил | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | олгогчоос төлөх ҮОМШӨ-ий даатгалын санд төлөх шимтгэлийг тооцох тохиргоог системд оруулах/. | | |
| | | Шинэчлэн батлагдсан маягтын дагуу НД7, НД8 тайланг зурж, ажил олгогчоос тайлан илгээх боломжийг бүрдүүлэх;<br>/ХНХСайд, Сангийн сайдын 2024.03.06-ны өдрийн №А/44, А/40 тоот тушаалаар баталсан загварын дагуу өөрчлөлт оруулах/. | | |
| | | СДД-ийн хувьд шимтгэл төлөх ЦХТАО-ын дээд хэмжээ нь тухайн үед мөрдөж буй сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс 7 дахин их байх өөрчлөлтийг оруулах; | | |
| | | ҮОМШӨ-ий даатгалын сангаас ХЧА-ны тэтгэвэр авагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг тус санд төлөх тооцооллыг хийхэд тухайн тэтгэвэр авагч ажил хөдөлмөр эрхэлж, шимтгэл төлж буй эсэхийг шалгах тохиргоо оруулах; | | |
| | | Шимтгэл нөхөн төлүүлэх /Улсын байцаагчийн актын дагуу ажил олгогчийн НДШ-ийн тайланг нөхөн тайлагнаж шимтгэлийг нөхөн төлүүлэх/ үед шимтгэл ногдох ЦХТАО-д итгэлцүүр хэрэглэх өөрчлөлт оруулах; | | |
| | | Цэргийн алба хаасан хугацааны шимтгэлийг нөхөн төлүүлэхэд цэргийн алба хаагчийн авч байсан ЦХТАО-ыг энэ хуулийн 22.2-т заасны дагуу тогтоосон итгэлцүүр хэрэглэсэн орлогоос тооцох тохиргоог хийх; | | |
| | | Хууль бусаар ажлаас чөлөөлөгдсөн нь шүүхийн шийдвэрээр тогтоогдож, өмнөх хугацааны цалинг олгохоор тооцсон тохиолдолд ЦХТАО-д ногдох шимтгэлийг нөхөн төлүүлэхэд итгэлцүүр хэрэглэх тохиргоог хийх; | | |
| | | Нэрийн дансны үлдэгдэл тооцох томъёог хуулийн дагуу өөрчлөх;<br>ҮА зардал, Мөнгөжүүлсэн орлого, Буцаан олгосон /олгохоор тооцсон/ шимтгэл зэргийг томъёонд зөв тохируулах; | | |
| | | “Нэрийн дансны орлогыг бүртгэх тусгай нөхцөл”-ийн дагуу нэрийн дансны орлогод бүртгэх орлогуудын тохиргоог системд нэмж оруулах | | |
| | **Хуулийн заалт** | **Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль** | | |
| | | Өндөр насны тэтгэврийн нөхцөл дээр Эмэгтэй тэтгэвэр авагч газрын дор нөхцөл нэмэх | | |
| | | Дээрх нөхцөлд даатгуулагч эмэгтэй бол насыг 45 хүрсэн байх гэсэн шалгалт оруулах | | |
| | | Дээрх нөхцөлд даатгуулагч тэтгэврийн даатгалын шимтгэлийг нийтдээ 20-оос доошгүй, үүнээс 7 жил 6 сараас доошгүй хугацаанд газрын дор нөхцлөөр ажилласан байх гэсэн шалгалт оруулах | | |
| 23 | | Хувь тэнцүүлсэн тэтгэврийн эрх үүсгэхдээ шимтгэл төлсөн хугацааны доод хязгаар 10 жил гэж шалгаж байж хүүхдийн жилийг нэмэх; | | |
| | | 1960-1978 онд төрсөн иргэдийн өндөр насны тэтгэврийг цалинд суурилсан болон нэрийн дансны гэсэн 2 аргаар бодох боломжийг бүрдүүлэх; | | |
| | | Томъёог сараар болгож өөрчлөх; /ерөнхий бодолтын томъёонууд/- тэтгэврийн бүх төрөл дээр | | |
| | | Илүү жилийн нэмэгдлийг оруулахдаа хөдөлмөрийн харилцаа дуусаагүй бол 6 сараас доошгүй, хөдөлмөрийн харилцаа дууссан бол сарын хязгаарлалт тавихгүйгээр тэтгэврийг нэмэгдүүлэх тохиргоог оруулах | | |
| 27 | | Тэтгэвэр тогтоосноос хойш шимтгэл төлсөн жилийн нэмэгдлийн томъёог сараар болгож өөрчлөх | | |
| | | ХЧА тэтгэвэр зогсоосноос хойш 6 сарын дотор дахин ХЧАлдсан бол тэтгэврийг дахин тогтоох тохиргоо хийх. Үүнтэй холбоотой “сэргээгдэх” хөдөлгөөн нэмэх; | | |
| | | Тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагчийн хөдөлмөрийн чадваргүй гишүүдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орсны дагуу системд өөрчлөлт оруулах; | | |
| | | Тэжээгчийг сураггүй алга болсныг нь тогтоож, нас барснаар тооцсон шүүхийн шийдвэр гарсан тохиолдолд 60 хүртэлх сарын тэтгэврийг энэ хуулийн 16.1-д заасан гэр бүлийн гишүүнд нөхөн олгох тохиргоо нэмэх | | |
| | | Тэтгэвэр тогтоолгох ЦХТАО-ыг тодорхойлохдоо 6-7 жилийн дундаж байсныг 5 жилийн дундаж цалингаас бодох өөрчлөлт оруулах | | |
| | | ЦХТАО-д хэрэглэх итгэлцүүрийг жил бүр шинэчлэн тогтоохтой холбогдуулан итгэлцүүр оруулан тооцох уян хатан функцтэй байх */Хуучин тэтгэвэр авагчид одоо мөрдөж байгаа итгэлцүүрээр, үүнээс хойш он онд шинээр тэтгэвэр тогтоолгогчдод тухайн оных нь батлагдсан итгэлцүүрийг хэрэглэхээр эрх зүйн зохицуулалт орсон/* | | |
| | | ТА-ны тэтгэврийн өргөдөл хүлээн авах хуулийн хугацааг өөрчлөх /30 хоног, хүндэтгэн үзэх шалтгаантай бол 6 сарын дотор/ | | |
| | | Тэтгэврийн хөдөлгөөнд түдгэлзүүлсэн, сэргээсэн хөдөлгөөн нэмэх | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 35 | | Түдгэлзүүлсэн, зогсоосон тэтгэврийг буцаан сэргээх тохиргоог оруулах | | |
| | | ХЧА-ытэтгэвэр авч байсан иргэн өндөр насны тэтгэвэр тогтоолгоход өмнө нь авч байсан ХЧА-ы тэтгэврээс буурч байвал өмнө авч байсан ХЧА-ы тэтгэврийн дүнгээр тогтоолт хийх өөрчлөлт оруулах | | |
| | **Хуулийн заалт** | **Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль** | | |
| | | ХЧТА-ны тэтгэмжийг ХЧТАлдахын өмнөх **дараалсан** 3 сар шимтгэл төлснөөр эрх үүсгэхээр тохиргоог өөрчлөх; | | |
| | | 66 ба 132 хоног дууссан тохиолдолд **дараалсан** 3-аас доошгүй сар шимтгэл төлсөн тохиолдолд дахин эрх үүсгэх тохиргоог оруулах; | | |
| | | Шимтгэл төлсөн хугацаанд харгалзан тэтгэмж тооцох хувь өөрчлөгдсөнийг системд нэмж оруулах, томъёог сараар өөрчлөх | | |
| | | ХЧТА-ны тэтгэмж олгох нэг удаагийн дээд хязгаар нь ажлын 66 өдрөөс хэтрэхгүй байсан зарим оношийн дээд хязгаар 132 хоног болж өөрчлөгдсөнийг нэмж тохируулах | | |
| 41 | | Жирэмсний болон амаржсаны тэтгэмж тооцоход нийтээр амрах баярын өдрийг ажлын өдөртэй адилтган тооцож тэтгэмж олгох хоногт оруулах өөрчлөлт хийх. */Долоо хоногийн амралтын өдөр нийтээр амрах баярын өдөртэй давхацвал мөн ажлын өдрөөр тооцох/* | | |
| 42 | | Ажилгүйдлийн тэтгэмж авах даатгуулагчид ердийн насны хязгаар шалгах өөрчлөлтийг оруулах. */Тэтгэврийн тухай хуулийн 5.1.1 дүгээр зүйлд заасан нас, уг заалтыг 5.3 дахь заалтын дор тайлбарласны дагуу насыг шалгах/* | | |
| 43 | | Өмнө нь ажилгүйдлийн тэтгэмж авч байсан даатгуулагчийн дахин тэтгэмж авах эрх үүсэх шалгуур өөрчлөгдсөнийг системд оруулах. */Дахин 12 сар, үүнээс ажилгүй болохын өмнөх 3 сар тасралтгүй гэсэн шалгуурыг тавих/* | | |
| 44 | | Хүүхдээ асрах чөлөөтэй байх хугацаандаа ажлаас чөлөөлөгдсөн тохиолдолд ажилгүйдлийн тэтгэмжийн эрх үүсгэхдээ сүүлийн тасралтгүй байх 9 сарыг чөлөө авахын өмнөх хугацаанаас шалгах өөрчлөлтийг оруулах; | | |
| 45 | | Хүүхдээ асрах чөлөөтэй байгаад ажилд ороод 9 сар болоогүй байхдаа ажлаас чөлөөлөгдсөн тохиолдолд ажилгүйдлийн тэтгэмжийн эрх үүсгэхдээ сүүлийн тасралтгүй байх 9 сарыг чөлөө авахын өмнөх хугацаанаас шалгах өөрчлөлтийг оруулах; | | |
| 46 | | Ажилгүйдлийн тэтгэмж тооцохдоо ажлаас чөлөөлөгдөхийн өмнө ажилгүйдлийн даатгалын санд шимтгэл төлсөн сүүлийн дараалсан 9 сарын цалингийн дунджаас тооцох өөрчлөлт оруулах. */Бодит цалингаас бодох/* | | |
| 47 | | Шимтгэл төлсөн жилд харгалзан ажилгүйдлийн тэтгэмж бодох хувь хэмжээ өөрчлөлгдсөнийг системд оруулах, томъёог сараар өөрчлөх | | |
| 48 | | Ажилгүйдлийн тэтгэмжийг олгохдоо даатгуулагчийг ажлаас чөлөөлсөн өдрийн дараагийн өдрөөс эхлэн 76 хоногоор тооцож олгох өөрчлөлтийг оруулах; | | |
| 49 | | Ажилгүйдлийн тэтгэмж тооцоход нийтээр амрах баярын өдрийг ажлын өдөртэй адилтган тооцож тэтгэмж олгох хоногт оруулах өөрчлөлт хийх. */Долоо хоногийн амралтын өдөр нийтээр амрах баярын өдөртэй давхацвал мөн ажлын өдрөөр тооцох/* | | |
| 50 | | Даатгуулагч ажлаас чөлөөлөх тухай ажил олгогчийн шийдвэр гарсан хоногоос хойш хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 28 хоногоос хоцорч нийгмийн даатгалын байгууллагад хүсэлт гаргасан тохиолдолд тэтгэмж олгох ёстой ажлын 76 өдрөөс хоцроосон хугацааны ажлын өдрийг хасч олгох тэтгэмжийг тооцох өөрчлөлтийг оруулах | | |
| 51 | | Даатгуулагч ажилгүйдлийн тэтгэмж авч байх хугацаандаа ажилд орж, албан журмаар шимтгэл төлж эхэлснээс хойш 5 сарын дотор ажлаас дахин чөлөөлөгдсөн бол анх тогтоосон ажилгүйдлийн тэтгэмжээс олгогдоогүй үлдсэн тэтгэмжийг олгох өөрчлөлт оруулах | | |
| | | Ажилгүйдлийн тэтгэмж олголтыг шалгах, зогсоох шалгалтуудыг нэмж оруулах /хуулийн 12.1 дэх заалтаар/ | | |
| 53 | | Ажилгүйдлийн тэтгэмжийг зогсоох үед дахин тооцоолол хийж илүү дутуу олголтыг тодорхойлох өөрчлөлтийг оруулах | | |
| | | ХЧТА-ны тэтгэмж авах хүсэлт гаргах хугацааг өөрчлөх /эмнэлгийн хуудас авснаас хойш 4 долоо хоног, хүндэтгэн үзэх шалтгаантай бол 6 сарын дотор/ | | |
| | | Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмж авах хүсэлт гаргах хугацааг өөрчлөх /нас барснаас хойш 6 долоо хоног, хүндэтгэн үзэх шалтгаантай бол 6 сарын дотор | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 56 | | Ажилгүйдлийн тэтгэмж авах хүсэлтийн хугацааг өөрчлөх /Ажлаас чөлөөлөх тухай шийдвэр гарсан өдрөөс 4 долоо хоног, хүндэтгэн үзэх шалтгаантай бол 3 сарын дотор/. | | |
| | **Хуулийн заалт** | **Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр тэтгэмж, төлбөрийн тухай хууль** | | |
| | | ҮОМШӨ-ний улмаас хөдөлмөрийн чадвараа 30 ба түүнээс дээш хувиар алдсан даатгуулагчид тухайн сангийн ХЧА-ны тэтгэвэр тогтоох эрх үүсэх тохиргоог оруулах; | | |
| | | ҮОМШӨ-ний даатгалын сангаас олгох ХЧА-ны тэтгэврийн хувьд даатгуулагч 12 сараас дээш хугацаанд тус санд шимтгэл төлсөн бол түүний ХЧАлдахын **өмнөх** 12 сарын цалин хөлсний нийлбэрийг 12-т хувааж дундаж цалин тооцох өөрчлөлт оруулах | | |
| | | ҮОМШӨ-ний даатгалын сангаас олгох ХЧА-ны тэтгэврийн хувьд даатгуулагч 12 сараас доош хугацаанд тус шимтгэл төлсөн бол түүний ХЧАлдахын **өмнө** шимтгэл төлсөн нийт ЦХТАО-ыг шимтгэл төлсөн сарын тоонд хувааж дундаж цалин тооцох өөрчлөлт оруулах; | | |
| | | ҮОМШӨ-ний даатгалын сангаас олгох ХЧА-ны тэтгэврийн хувьд даатгуулагч 1 сараас доош хугацаанд ажиллаж байгаад ХЧАлдсан бол /тухайн санд шимтгэл төлөөгүй байхдаа/ ХЧАлдсан тухайн сарын шимтгэл төлсөн ЦХТАО-ын дүнгээр дундаж цалин тооцох өөрчлөлт оруулах /*Энэ тохиолдолд ажил олгогч нь тухайн сард даатгуулагчийн ажилд томилсон шийдвэрээр тогтоосон ЦХТАО-оос тооцож НДШ-ийг тайлагнана гэж ойлгоно/* | | |
| | | ҮОМШӨ-ий даатгалын сангаас ХЧА-ны тэтгэвэр авагч нь тэтгэвэр тогтоолгосноос хойш 12 сараас доошгүй хугацаанд шимтгэл төлж байж илүү жилийн нэмэгдэл авах өөрчлөлтийг оруулах | | |
| | | Даатгуулагч хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг хүндэтгэн үзэх шалтгаанаар тогтоолгоогүй байснаа нөхөн тогтоолгосон бол 6 хүртэлх сарын тэтгэврийг нөхөн олгох өөрчлөлтийг оруулах | | |
| | | ҮОМШӨ-ний даатгалын сангаас ХЧА-ы тэтгэвэр авагч нь хөдөлмөрийн чадвар алдалтын тогтоосон хугацаа дууссанаас хойш хүндэтгэн үзэх шалтгаанаар хугацаа хожимдон нөхөн сунгуулсан бол түүний 2 хүртэлх сарын тэтгэврийг нөхөн олгох өөрчлөлтийг оруулах; | | |
| | | Даатгуулагчийг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас нас барсныг нөхөн тогтоосон бол 6 сараас илүүгүй хугацааны тэжээгчээ алдсаны тэтгэврийг нөхөн олгох өөрчлөлтийг оруулах; | | |
| | | ҮОМШӨ-ний даатгалын сангаас олгох ХЧТА-ы тэтгэмжийн хувьд даатгуулагч 3 сараас дээш хугацаанд тус санд шимтгэл төлсөн бол түүний ХЧАлдахын **өмнөх** 3 сарын цалинг хөлсний нийлбэрийг 3-т хувааж дундаж цалин тооцох өөрчлөлт оруулах | | |
| | | ҮОМШӨ-ний даатгалын сангаас олгох ХЧТА-ы тэтгэмжийн хувьд даатгуулагч 3 сараас доош хугацаанд тус санд шимтгэл төлсөн бол түүний ХЧАлдахын **өмнө** шимтгэл төлсөн нийт ЦХТАО-ыг шимтгэл төлсөн сарын тоонд хувааж дундаж цалин тооцох өөрчлөлт оруулах | | |
| | | ҮОМШӨ-ний даатгалын сангаас олгох ХЧТА-ны тэтгэмжийн хувьд даатгуулагч 1 сараас доош хугацаанд ажиллаж байгаад ХЧАлдсан бол /тухайн санд шимтгэл төлөөгүй байхдаа/ ХЧАлдсан тухайн сарын шимтгэл төлсөн ЦХТАО-ын дүнгээр дундаж цалин тооцох өөрчлөлт оруулах. */Энэ тохиолдолд ажил олгогч нь тухайн сард даатгуулагчийн ажилд томилсон шийдвэрээр тогтоосон ЦХТАО-оос тооцож НДШ-ийг тайлагнана гэж ойлгоно/* | | |
| | | ҮОМШӨ-ий улмаас ХЧА-ы тэтгэвэр авагчид тухайн тэтгэвэр тогтоолгосон өвчний оношоор ХЧТА-ы тэтгэмжийг давхардуулан олгохгүй байх шалгалтыг системд оруулах | | |
| | | ҮОМШӨ-ий улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан даатгуулагч эрүүл мэндийн даатгалын сангаас, эсхүл нийгмийн халамжийн сангаас протез, ортопедийн зардлын төлбөрийг гаргуулсан бол үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас зардлын төлбөрийг давхардуулан олгохгүй байх шалгалтыг системд оруулах | | |
| 70 | | Монгол улсад протез, ортопед хийлгэсэн даатгуулагч хэдэн ч удаа авсан жишиг үнийн 100%-иар тооцон олгох өөрчлөлтийг системд оруулах | | |
| 71 | | Гадаад улсад протез, ортопед хийлгэсэн даатгуулагч хэдэн ч удаа авсан жишиг үнийн 100%-иар тооцон олгох өөрчлөлтийг системд оруулах | | |
| | | Дээрх 2 тохиолдлын аль алинд нь протез ортопедийн зардлыг 3 жилд нэг удаа олгох шалгуурыг системд тохируулах | | |

2. 2023 оны 07 дугаар сарын 07-ний өдрийн УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар нийгмийн даатгалын багц хуулийг шинэчлэн баталсантай холбогдуулан нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн системд хуулийн өөрчлөлтийг дагуу дараах шинэ бүтээгдэхүүнийг нэмж хөгжүүлэх

| **№** | ***Захиалагчийн техникийн тодорхойлолт***<br>***(Хийгдэх өөрчлөлтийн агуулга)*** | | ***Санал болгож буй техникийн тодорхойлолт***<br>***захиалагчийн техникийн тодорхойлолтыг хуулахгүй байхыг анхаарна уу. Зөвхөн санал болгож буй барааны техникийн тодорхойлолтыг бичнэ үү.)*** | ***Тайлбар***<br>***(дээрх үзүүлэлтийг нотлох баримт бичиг болон танилцуулгыг хавсаргана)*** |
|---|---|---|---|---|
| | **Хуулийн заалт** | **Нийгмийн даатгалын ерөнхий хууль** | | |
| | | **18 хүртэл насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч буй сайн дураар даатгуулагчид зориулсан шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэх**. | | |
| | | • 18 хүртэл насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн мэдээллийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын мэдээллийн сангаас цахимаар шалгах;<br>• Дээрх шаардлагыг хангасан хүүхдийг асарч байгаа эцэг, эхийн мэдээллийг Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газрын мэдээллийн сангаас цахимаар шалгах;<br>• Дээрх шаардлагуудыг хангасан иргэн “Сайн дурын даатгал /Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа эх, эцэг” бүтээгдэхүүний төрлөөр хүсэлт гаргах боломжтой байхаар тохируулах;<br>• “Сайн дурын даатгал /Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа эх, эцэг” бүтээгдэхүүний төрлөөр хүсэлт гаргах үед өөрөө хариуцан төлөх болон улсын төсвөөс хариуцан төлөх шимтгэлийн хэмжээг тооцоолон харуулах;<br>• Даатгуулагч өөрөө хариуцан төлөх шимтгэлээ төлсөн тохиолдолд улсын төсвийн авлагыг үүсгэх боломжтойгоор тохируулах;<br>• ХНХСайдын 2023.12.25-ны өдрийн №А/200 тоот тушаалаар баталсан загварын дагуу тухайн бүтээгдэхүүний гэрээг тохируулах;<br>• Энгийн сайн дураар даатгуулагчийн адилаар төлөлт хийх, гэрээ, үйлчилгээгээ харах, лавлагаа тодорхойлолт авахаар тохируулах;<br>• Бүтээгдэхүүний хүсэлтийг иргэн цахимаар гаргах болон Sicos систем дээр үүсгэх, бүртгэх боломжтойгоор тохируулах. | | |
| | | **Малчин сайн дураар даатгуулагчид зориулсан шинэ бүтээгдэхүүн нэмж хөгжүүлэх.** | | |
| | | • Малчин шаардлагыг хангасан иргэн “Сайн дурын даатгал /Малчин, туслах малчин” бүтээгдэхүүний төрлөөр хүсэлт гаргах боломжтой байхаар тохируулах;<br>• “Сайн дурын даатгал /Малчин, туслах малчин” бүтээгдэхүүний төрлөөр хүсэлт гаргах үед өөрөө хариуцан төлөх болон улсын төсвөөс хариуцан төлөх шимтгэлийн хэмжээг тооцоолон харуулах;<br>• Даатгуулагч өөрөө хариуцан төлөх шимтгэлээ төлсөн тохиолдолд улсын төсвийн авлагыг үүсгэх боломжтойгоор тохируулах;<br>• ХНХСайдын 2023.12.25-ны өдрийн №А/200 тоот тушаалаар баталсан загварын дагуу тухайн бүтээгдэхүүний гэрээг тохируулах;<br>• Энгийн сайн дураар даатгуулагчийн адилаар төлөлт хийх, гэрээ, үйлчилгээгээ харах, лавлагаа тодорхойлолт авахаар тохируулах;<br>• Бүтээгдэхүүний хүсэлтийг иргэн цахимаар гаргах болон Sicos систем дээр үүсгэх, бүртгэх боломжтойгоор тохируулах. | | |
| | | **Тэтгэврийн нөөц санг бүрдүүлэх, мөнгөжүүлсэн орлогогыг тооцох, бүртгэхтэй холбоотой бүтээгдэхүүнийг шинээр хөгжүүлэх** | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | • Даатгуулагчийн ЦХТАО-оос тэтгэврийн даатгалын санд тулж буй ажил олгогч, даатгуулагчийн тус бүр 1%-ийн шимтгэлийн дүнгээр даатгуулагч тус бүрийн мөнгөжүүлэхээр тооцсон орлогыг бүртгэх тохиргоо оруулах /дээд хэмжээг анхаарах/.<br>• Ажил олгогчийн төлсөн шимтгэлээс хамааруулан мөнгөжүүлэхэд бэлэн болсон орлогыг даатгуулагч тус бүрээр бүртгэх тохиргоог оруулах /Нэгээс олон байгууллагад ажиллаж шимтгэл төлдөг даатгуулагчийн хувьд эхэлж төлсөн ажил олгогчийн төлөлтөөс даатгуулагчийн төлөх хувь хэмжээг гүйцээх/.<br>• Нөөц сангийн дансанд байршуулсан дүнгээр даатгуулагч тус бүрээр мөнгөжүүлсэн орлогыг бүртгэх тохиргоог оруулах;<br>• Мөнгөжүүлсэн орлогоос даатгуулагчийн саналыг үндэслэн 13.1-д заасан хөрөнгө оруулалтаас сонгох тохиргоог хийх; | | |
| | **Хуулийн заалт** | **Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль** | | |
| | | **ӨН тэтгэвэр авч байгаад нас барсан тохиолдолд эхнэр /нөхөр/-ийн тэтгэвэр дээр түүний авч байсан тэтгэврийн 20%-ийг нэмэгдүүлэх бүтээгдэхүүн шинээр хөгжүүлэх** | | |
| | | • Гэрлэлтийн бүртгэлийн мэдээллийг УБЕГ-ын мэдээллийн сангаас цахимаар шалгах;<br>• Гэрлэлтийн бүртгэлийн мэдээллийн цаасан лавлагааг бүртгэхээр тохируулах;<br>• Хамт амьдарсан хугацааны доод хязгаар 240 сар байхаар шалгах тохиргоо хийх;<br>• Гэрлэлт бүртгүүлсэн, 20-оос доошгүй жил хамтын амьдралтай байсныг шалгах шалгуур оруулах, УБЕГ-аас сервисээр мэдээлэл авах;<br>• Энэхүү нэмэгдэл тэтгэврийн эхэлж олгох огноог хуулийн дагуу зөв тохируулах;<br>• Нас барсан тэтгэвэр авагч нь 1995 оноос өмнө тогтоолгосон бол түүний эхнэр, нөхөрт олгох нэмэгдэл тэтгэврийг улсын төсвөөс олгохоор тохируулах. | | |
| | | **Өмнө 6-7 жилийн дундаж цалинд суурилан тэтгэвэр тогтоолгосон иргэдийн тэтгэврийг 5 жилийн дундаж цалингаар өөрчлөн тогтоох бүтээгдэхүүн шинээр хөгжүүлэх** | | |
| | **Хуулийн заалт** | **Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр тэтгэмж, төлбөрийн тухай хууль** | | |
| | 4.1.4<br>10 | **ҮОМШӨ-ний даатгалын сангаас нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмж шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэх** | | |
| | | • ҮОМШӨ-ний улмаас нас барсан бол уг бүтээгдэхүүн дээр эрх үүсэх тохиргоог оруулах;<br>• ҮОМШӨ-ний даатгалын сангаас ХЧА-ны тэтгэвэр авч байсан иргэн нас барсан бол уг бүтээгдэхүүн дээр эрх үүсэх тохиргоог оруулах;<br>• Олгох тэтгэмжийн хэмжээ нь “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай” хуулийн 8.3-т заасны дагуу тогтоосон тогтмол хэмжээ байхаар тохируулах; | | |

3. Иргэд, даатгуулагч, ажил олгогчдод хөдөлгөөнт төхөөрөмж болон вэб технологид суурилан үзүүлж байсан бүтээгдэхүүн, үйлчилгээг нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн системийн бүтцэд тохируулан шинэчлэх

| **№** | ***Захиалагчийн техникийн тодорхойлолт*** | ***Санал болгож буй техникийн тодорхойлолт*** <br> ***(захиалагчийн техникийн тодорхойлолтыг хуулахгүй байхыг анхаарна уу. Зөвхөн санал болгож буй барааны техникийн тодорхойлолтыг бичнэ үү.)*** | ***Тайлбар*** <br> ***(дээрх үзүүлэлтийг нотлох баримт бичиг болон танилцуулгыг хавсаргана)*** |
|---|---|---|---|
| 1 | Сайн дураар даатгуулах 4 бүтээгдэхүүнийг шинэчлэн тохируулах <br> o Сайн дурын даатгал /энгийн/ <br> o Сайн дурын даатгал /малчин, туслах малчин/ <br> o Сайн дурын даатгал /Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа эх, эцэг/ <br> o Сайн дурын даатгал /3 хүртэлх насны хүүхдээ асарч байгаа эх/ | | |
| 2 | Тэтгэмж олголтын 4 бүтээгдэхүүнийг шинэчлэн тохируулах <br> o Жирэмсны болон амаржсаны тэтгэмж <br> o Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж <br> o ҮОМШӨ Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж <br> o Ажилгүйдлийн тэтгэмж | | |
| 3 | Төлбөр төлөлтийн үйлчилгээг шинэчлэн тохируулах | | |
| 4 | Лавлагаа, тодорхойлолтын 3 бүтээгдэхүүнийг шинэчлэн тохируулах; <br> o Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт <br> o Иргэн /даатгуулагч/-д нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх үүсээгүй тухай тодорхойлолт <br> o Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны лавлагаа | | |
| 5 | Шинэчлэн нэвтрүүлж буй системийн бүтээгдэхүүн үйлчилгээтэй холбоотой иргэд даатгуулагчдад хүргэх мэдээлэл /notification/-ийг цахим хэрэгсэлд суурилан илгээх | | |
| 6 | Тэтгэврийн нөөц сан, мөнгөжүүлсэн орлогын мэдээллийг иргэдэд хүргэх | | |
| 7 | Иргэн овог, нэр, регистрээ сольсон тохиолдолд сольсон тухай мэдээллийг оруулдаг байх | | |
| 8 | Иргэд, даатгуулагч, ажил олгогч өөрийн бусад мэдээллээ шинэчлэх боломжтой байх | | |
| 9 | Хэрэглэгч нууц үгээ алдсан тохиолдолд сэргээх, засварлах боломжтой байх | | |

4. Хууль тогтоомжид орсон өөрчлөлтийн дагуу нягтлан бодох бүртгэл, санхүүгийн мэдээ, тайлангуудад оруулах нэмэлт хөгжүүлэлт

| *№* | *Захиалагчийн техникийн тодорхойлолт* | *Санал болгож буй техникийн тодорхойлолт* *(захиалагчийн техникийн тодорхойлолтыг хуулахгүй байхыг анхаарна уу. Зөвхөн санал болгож буй барааны техникийн тодорхойлолтыг бичнэ үү.)* | *Тайлбар* *(дээрх үзүүлэлтийг нотлох баримт бичиг болон танилцуулгыг хавсаргана)* |
|---|---|---|---|
| 1 | Шинээр нэмэгдсэн бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой дансны төлөвлөгөөг өргөжүүлэх | | |
| 2 | Шинэ бүтээгдэхүүнүүдийн нягтлан бодох бүртгэлийн тохиргоо хийх | | |
| 3 | Нэмэгдсэн нягтлан бодох бүртгэлийн дансуудад холбогдох гүйлгээний төрлийг нэмэх | | |
| 4 | Нэмэгдсэн НББ-ийн данс, гүйлгээнүүдийн төрлийг журнал, ерөнхий дэвтэрт холбох | | |
| 5 | Нэмэгдсэн НББ-ийн данс, гүйлгээний төрлүүдийг төсвийн гүйцэтгэлийн мэдээтэй холбох | | |
| 6 | Нэмэгдсэн НББ-ийн данс, гүйлгээний төрлүүдийг санхүүгийн тайлан хавсралт тайлангуудтай холбох | | |
| 7 | Хуулийн дагуу шинээр нэмэгдсэн бүтээгдэхүүн үйлчилгээг бүрэн багтаасан санхүүгийн тайлан балансыг гаргах | | |

## 5. Ерөнхий шаардлага

| № | *Захиалагчийн техникийн тодорхойлолт* | ***Санал болгож буй техникийн тодорхойлолт*** *(захиалагчийн техникийн тодорхойлолтыг хуулахгүй байхыг анхаарна уу. Зөвхөн санал болгож буй барааны техникийн тодорхойлолтыг бичнэ үү.)* | ***Тайлбар*** *(дээрх үзүүлэлтийг нотлох баримт бичиг болон танилцуулгыг хавсаргана)* |
|---|---|---|---|
| 1 | Дээр дурдагдсан бүтээгдэхүүн үйлчилгээний бизнес процесс нь Activiti framework ашигласан байх | | |
| 2 | Нэмэлтээр хийгдсэн өөрчлөлт хөгжүүлэлт нь нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн системд бүрэн зохицон ажиллах | | |
| 3 | Нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн системд ашиглагдаж буй бизнес процессыг хэвээр үлдээж, нэмэлтээр хийгдсэн өөрчлөлт хөгжүүлэлтийг шинэ хувилбар үүсгэх байдлаар хөгжүүлэх | | |
| 4 | Нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн систем болон нэмэлт өөрчлөлт, хөгжүүлэлтээр МТТ-ийн ажилтнуудад сургалт зохион байгуулах | | |
| 5 | Нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн системд хийгдсэн нэмэлт өөрчлөлт, хөгжүүлэлтийн систем, ашиглалт болон хэрэглэгчийн гарын авлагыг боловсруулан хүлээлгэн өгөх | | |
| 6 | Нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн системийн болон хийгдсэн нэмэлт өөрчлөлт, шинэчлэлтийн техникийн баримт бичгийг боловсруулан бүрэн хүлээлгэн өгөх | | |
| 7 | Хууль тогтоомжийн өөрчлөлтийн дагуу нийгмийн даатгалын нэгдсэн мэдээллийн системийн өөрчлөлт, хөгжүүлэлттэй уялдан системийн архитектурт өөрчлөлт орох шаардлагатай гэж үзвэл тухайн архитектурын өөрчлөлтийг хийж гүйцэтгэн архитехтурын бичиг баримтыг шинэчлэн хүлээлгэн өгөх | | |